



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 07 өдөр

Дугаар А/163

Бат-Өлзий сум

Худаг хүлээн авах ажлын хэсэг
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавралтаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.3.8, 9.12 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2 дугаар багийн Билүүтэд баригдсан худгийг хүлээн авах ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Орхонтуул (Засаг даргын орлогч)
Гишүүд: Д.Бямбасүрэн (2 дугаар багийн Засаг дарга)
Н.Түвшин (Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)
Х.Дагвадулам (сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
төлөөлөгч)
Г.Гантулга (иргэний төлөөлөл)

2. Захиалагчийн техникийн тодорхойлолт, шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа байдлыг хянан үзэж, гэрээний шаардлагыг биелүүлсэн нөхцөлд акт үйлдэн хүлээн авахыг ажлын хэсэг (Н.Орхонтуул)-д, хөрөнгийг байгууллагын өмчийн бүртгэлд бүртгэхийг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам) нарт тус тус даалгасугай.

3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжсэн 2 дугаар багийн Билүүтэд баригдсан гүний худгийн ашиглалт, хамгаалалтад байнгын хяналт тавьж ажиллахыг Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дарга (Н.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН

0222 02337

D:My Doc A-4 zahiramj /Zasag darga/